



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 16 өдөр

Дугаар 4/171

Хархорин сум

Мал, амьтны гоц халдварт бог малын мялзан
өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5, 9.6, 9.7, 9.8 дахь заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/298 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/647 дугаар захирамж, Мал эмнэлгийн газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн Мал, амьтны гоц халдварт бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай А/30 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны гоц халдварт бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг хийж гүйцэтгэх, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Лхагвасүрэн (Засаг даргын орлогч)

Гишүүд: Ц.Пүрвээ ("Дэлийн бүрд" мал эмнэлгийн захирал)
А.Сайнбилэг ("Аяган зураа" мал эмнэлгийн захирал)
Т.Алтангэрэл (1 дүгээр багийн Засаг дарга)
Р.Сүхбат (2 дугаар багийн Засаг дарга)
Д.Батчулуун (3 дугаар багийн Засаг дарга)
Г.Отгонбаяр (4 дүгээр багийн Засаг дарга)
Б.Ганхуяг (5 дугаар багийн Засаг дарга)
Л.Төгөлдөр (6 дугаар багийн Засаг дарга)
О.Батсүх (7 дугаар багийн Засаг дарга)
П.Нэндарам (8 дугаар багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: Э.Нарангарав (Мал эмнэлгийн тасгийн дарга)

2. Мал, амьтны гоц халдварт бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор шуурхай зохион байгуулсугай.

3. Дархлаажуулалтын товыг малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч нарт зарлан мэдээлж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

4.Товлосон хугацаанд мал, амьтныг бэлэн байлгаж, бүрэн хамруулж, барьж бэхлэн, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдүүлэх, малын эмчийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг малчин, мал бүхий иргэдэд үүрэг болгосугай.

5.Мал, амьтны гоц халдварт бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг мэргэжил арга зүйгээр хангаж, ажлын явц үр дүнд хяналт тавьж, идэвхтэй тандалт хийж ажиллахыг мал эмнэлгийн тасгийн дарга (Э.Нарангарав)-д даалагсугай.

6.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Лхагвасүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ОДГЭРЭЛ